



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/287

Эрдэнэт

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх, хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн хэмжээнд олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярыг “Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай” уриан дор 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдөр бүх нийтээр тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Хүүхдийн баярын үйл ажиллагааг зохион байгуулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шаардагдах зардал 4484000 /Дөрвөн сая дөрвөн зуун наян дөрвөн мянган / төгрөгийг Засаг даргын нэрэмжит болон соёл, спорт, хүүхэд залуучуудын арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэгт/-т зөвшөөрч, Баярын арга хэмжээг гэр бүлд өгөөжтэй хэлбэрээр зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн оролцоог ханган ажиллахыг ажлын хэсэг /н.Түвшинжаргал/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc
0200001357

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 23 өдрийн 168 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ӨДӨР,
ХҮҮХДИЙН БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зохион байгуулах ажил	Нэг бүр	Тоо ширхэг	Нийт
1.	Хөгжлийн бэрхшээлтэй байнгын хэвтэрт байдаг хүүхдэд тусламж үзүүлэх, бэлэг өгөх	40000	15	600000
2.	Бүтэн өнчин хүүхдэд тусламж үзүүлэх, бэлэг өгөх	40000	15	600000
3.	Зорилтот бүлгийн хүүхдүүдэд бэлэг өгөх	15000	50	750000
4.	Урлагийн тоглолтод оролцсон хүүхдүүдэд өгөх урамшуулал	12500	50	625000
5.	Авъяастан төвийн хүүхдүүдийн урлагийн тоглолтыг урамшуулах	12500	30	375000
6.	Аз жаргалын бөмбөлөг хөөргөх үйл ажиллагааны зардал			500000
7.	Анонс хэвлүүлэх	6x8	8000	384000
8.	Соёлын төвийн хүүхдүүдийн тоглолтыг урамшуулах / Баян- өндөр, Эгшиглэнт, Жаргалант соёлын төвүүд/	2500	60	150000
8	Дугуйлангийн хаягнууд хийх	10000	10	100000
9.	6-р сарын 01-ний өдөр мэндэлсэн хүүхдүүд, тэдгээрийн ээжүүдэд бэлэг өгөх	10	30000	300000
10	Хөтлөгчийн урамшуулал	2	50000	100000
	Нийт дүн			4.484.000